

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа:	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Техник импорт ХК УБГД:9010001041 ҮЦК: 441 Утасны дугаар: (+976) 70001830
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	144,675,5
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Санхүү, бизнес хариуцсан захирал С.Дашдулам ТУЗ-ын н.б.д О.Бүжинлхам Хянасан: Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг
1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
2. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	

	<p>Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлаараа компанийн хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргасан.</p> <p>Тус Аудитын хорооны хурлаас Техник импорт ХК-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах бүх өр төлбөр, орлого, зардал, хөрөнгийг МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлж тусгасан байна гэж дүгнэсэн.</p>	
3.	<p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</p>	
3.1.	<p>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</p>	<p>1. Цэвэр хүүний маржин (NIM) 1,83%</p> <p>2. Нийт хөрөнгийн өгөөж ( ROA) 0,01%</p> <p>3. Өөрийн хөрөнгийн өгөөж ( ROE ) 0,04%</p> <p>4. Нийт активын өөрчлөлт 7,09%</p> <p>5. Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө 0,27%</p> <p>6. Өр төлбөр/Нийт хөрөнгө 0,04%</p> <p>7. Хөрвөх чадвартай хөрөнгө 95.54%</p>
3.2.	<p>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</p>	
3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад валютын ханш, импортын болон дотоодын бараа, материалын үнэ чухал нөлөө үзүүлдэг.</p> <p>Тайлант хугацаанд инфляцийн өсөлтөөс шалтгаалан бараа, материалын үнэ өсч бэлэн мөнгөний хомсдол үүсгэсэн нь компанийн борлуулалтын үйл ажиллагаанд нөлөөлж харилцагч, үйлчлүүлэгчдийн худалдан авах чадварыг бууруулах гол хүчин зүйл болсон.</p> <p>Компанийн холбогдох албадаас зохих журмын дагуу судалгаа хийж судалгаагаар гарсан дүгнэлт, судалгааны үзүүлэлтийг үндэслэн харилцагч, үйлчлүүлэгч бүрийн онцлогт нийцүүлэн бараа, бүтээгдэхүүний борлуулалт хийж компанийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.</p>
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хурлаараа Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 35 тэрбум төгрөгийн зээл авах асуудлыг хэлэлцсэн. Тус хурлаас 35 тэрбум төгрөгийг 18 сарын хугацаатай, жилийн 14.4%-ийн хүүтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу үл хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлогоос орж ирэх мөнгөн орлогыг барьцаалуулах эрхийг Гүйцэтгэх удирдлагад олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны журам”-д заасны дагуу болон уг журамд заасан хугацаанд зээлийн талаар хэлэлцсэн ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох материалын хамт СЗХ-нд</p>	

хүргүүлж ажилласан.

5. *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл*

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.

5. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

**Компанийн удирдлагын бүтэц:**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Төлөөлөн удирдах зөвлөл
3. Гүйцэтгэх удирдлага

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулдаг.

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 16 цагт компанийн “Хурлын танхим”-д болсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-иас гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-ны дагуу бүртгэж баталгаажуулсан.

Компаниас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-гаар 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн бүртгэлийн өдрөөр 459 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн.

Компанийн нийт хувьцааны 10 ба түүнээс дээш Хувьцаа эзэмшигчдийн нэрс:

№	Овог нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480300	33,2%

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсон.

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
3. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
4. 2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт
5. 2023 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцсэн асуудлуудыг дэмжиж хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж. Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг тус тус сонгож баталсан.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог байгуулсан.

ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтээр ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчдийг ХЭХ-аар хэлэлцүүлж сонгосон ба ТУЗ-ын гишүүнээр сонгогдсон 9 гишүүн нь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, холбогдох хууль, журамд заасан шаардлагыг бүрэн

хангасан.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Дүрэм, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

1. Хамтарсан компанийн Гүйцэтгэх удирдлагыг томилох тухай /2023.02.07 №01/
2. Ногдол ашиг хуваарилах тухай /2023.02.15 №02/
3. 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2023.02.15 №03/
4. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын компаниар баталгаажуулах зөвшөөрөл олгох тухай /2023.02.22. №04/
5. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2023.05.11 №05/
6. Компанийн засаглалын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор журам батлах тухай /2023.05.19 №06/

ТУЗ-ын нийт хуралд 9 гишүүн оролцож хурлаар хэлэлцсэн асуудлыг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

### Гүйцэтгэх удирдлага

Компанийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу “2023 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө”-г болон холбогдох ХЭХ-ын шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг компанийн Гүйцэтгэх удирдлагаас үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

Компанийн дотоод аудитын алба нь Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу “Санхүүгийн дотоод аудитын журам”, “Чанарын дотоод аудитын журам”-аар олгосон чиг үүргийн хүрээнд компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд аудит хийж ажлын үр дүнг Гүйцэтгэх удирдлагад танилцуулж ажилласан.

Тайлант хугацаанд “Дотоод аудитын алба”-ны хариуцсан ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайланг ТУЗ-ын Аудитын хороо зохих журмын дагуу хэлэлцэж дүгнэлт гаргаж ажилласан.

### 6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Компанийн тухай хууль, компанийн Дүрэм болон холбогдох журамд заасны дагуу 2022 оны ногдол ашгийн тайланг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнасан.

Ногдол ашгийн тайланг 2023 оны ХЭХ-ын шийдвэр, тогтоол, материалын хамт СЗХ, МХБ ТӨХК-д хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн “Үүрэг даалгавар өгөх тухай” албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-иас ирүүлсэн “Хамтран ажиллах тухай” албан бичгийн дагуу холбогдох хууль, журамд заасан хугацаанд компаниас дараах мэдээллийг хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
2. Техник импорт ХК-ийн 2022 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол
3. Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоол, холбогдох материал
4. Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, тогтоол, холбогдох материал
5. Техник импорт ХК-ийн 2022 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт
6. Техник импорт ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан
7. Банкнаас зээл авах эрх олгох тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол, холбогдох материал
8. Техник импорт ХК-ийн 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

9. Техник импорт ХК-ийн 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан

Тайлант хугацаанд компанийн засаглалын үнэлгээний тайланг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж ажилласан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: *Д. Ганзориг*.....

Овог, нэр: .....

Албан тушаал: “Техник импорт” ХК-ийн

Албан тушаал: “.....” ..К аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: *Д. Ганзориг*.....

Гарын үсэг: .....



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын н.б.д

Гарын үсэг: *О. Бүжинлхам*.....